



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/Б40

Мөрөн сум

Гадна тохижилтын ажил хүлээж авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6 Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Ханх сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч)

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Д.Мягмарсүрэн (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Д.Аюушжав (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Харилцаа, холбооны хяналтын улсын байцаагч)

Ж.Нацагдорж (Аймгийн онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

Б.Аюуш ("Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн Ашиглалтын албаны дарга)

Ч.Баярсайхан ("Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ газрын хяналтын инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Б.Төрбат ("Криетив монголиа" ХХК-ийн инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Б.Нэргүй ("ЖЕМНН" ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:
Л.Даваабаяр (Ханх сумын Засаг дарга)

Ж.Батцэцэг (Ханх сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч)
Б.Баасанхүү (Ханх сумын эрчим хүчний байцаагч)

Комиссын нарийн бичгийн дарга:
Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
мэргэжилтэн)

2. Гадна тохижилтын ажил хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Гадна тохижилтийн ажил хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй гадна тохижилтын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН